



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/267

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Татвар төлөгчдийн өдрийг тохиолдуулан улс, орон нутгийн төсөвт бусдыгаа хошуучлан татвараа төлсөн “Шонхорын хүлэг транс” ХХК, “Ховд мөнх түшиг” ХХК, “Маралжин” ЗБН зэрэг байгууллагуудыг аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 90000 төгрөг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 90000 төгрөг /ерэн мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны  
05 дугаар сарын 03-ны өдрийн  
А/267 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН “ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ”-ӨӨР  
ШАГНАГДАХ БАЙГУУЛЛАГЫН НЭРС

№	Байгууллагын нэр	Эрхэлж буй ажил, үйлчилгээ	Олгох шагнал
1	“Шонхорын хүлэг” ХХК	Улс болон хот хоорондын ачаа тээвэр, тээвэр зуулчлалын үйлчилгээ, гадаад худалдаа	30000
2	“Ховд мөнх түшиг” ХХК	Үйлдвэрийн барилгын төмөр битон хийц, явган зам талбайн хавтан, өнгөлгөөний битон тоосгоны үйлдвэрлэл, барилга, угсралт, засварын ажил	30000
3	“Маралжин” ЗБН	Эм зүйн 24 цагийн тусламж үйлчилгээ	30000
Дүн			900000

-oOo-